



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 76

Мөрөн

┌ Ээлжит бус хуралдаан товлон зарлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дах заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн ИТХ-ын ээлжит бус XII хуралдааныг 2015 оны 11 дүгээр сарын 13 -ны өдрийн 10 цагт Мөрөн сумын төвд хуралдуулахаар товлон зарласугай.

Хоёр. Аймгийн ИТХ-ын ээлжит бус XII хуралдаанаар доорх асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

1. Аймгийн нийгэм, эдийн засгийг 2008-2015 онд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тухай
2. Аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр батлах тухай
3. Аймгийн 2015 оны төсөвт тодотгол хийх тухай
4. Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний экспертизийн дүнг хэлэлцэж төлөвлөгөөг батлах тухай
5. Мөрөн сумын Зүүн-Мөрөн, Шинэ- Мөрөн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай
6. Хатгал тосгоныг сум болгох ажлын хэсгийн саналыг хэлэлцүүлэх тухай

Гурав. Хуралдааны бэлтгэлийг бүрэн хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч С.Цогтоо, Засаг даргын тамгын газрын дарга Г.Төмөрбаатар нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БОЛДБААТАР

910299